

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам



ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Хувилбарын дугаар: 2

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023 оны 10 сарын 30 өдөр

Баримт бичгийн дугаар:

Баримт бичгийг хариуцах нэгж	Баримт бичгийн нгууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
Боловсруулсан:	Гүйцэтгэх удирдлагын баг	ЭТҮЧАБ Албаны менежер Л.Золзаяа Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Э. Мөнхцэцэг	Албан тушаал	Гарын үсэг
Санал өгсөн хянасан:	Гүйцэтгэх удирдлагын баг	Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Д.Болормаа ЭТҮЧАБ Албаны дарга Ц.Лувсандамдин	Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Д.Болормаа	Гарын үсэг
Хянаж багласан:		БОЗТ-ийн захирал	БОЗТ-ийн захирал	Гарын үсэг



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсоныг товч тайлбарлана)
1	2023.10.30		
2			
3			

АГУУЛГА

1. ЗОРИЛГО
2. ХАМРАХ ХҮРЭЭ
3. ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР
4. ИШ ТАТСАН БАРИМТУУД
5. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН МАТРИЦ
6. ЯТТ-ИЙН ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛИЙН ҮҮРЭГ
7. ЯТТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
8. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
9. ЖИЖҮҮР ХҮЛЭЭЛЦЭХ
10. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АР ГЭРИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА
11. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭРХЛЭГЧИЙН ХАРИУЦЛАГА
12. ТАСАГ ХООРОНД ӨВЧТӨН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ
13. НАС БАРАЛТЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
14. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АР ГЭРТ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ
15. ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС ТАНИУЛАХ
16. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТ
17. ЯТТ-ИЙН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ
 - 17.1 ЯТТ-ИЙН ЭМ ЭМНЭЛГИЙН НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЭЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ
 - 17.2 ЯТТ-Д ХЭРЭГЛЭГДЭХ ЦОМГИЙН ЖАГСААЛТ
 - 17.3 АНХАН ШАТНЫ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай Тусламжийн Тасагт үйлчлүүлэгч орж ирэхээс эхлэн тусламж үйлчилгээний авч шийдэгдэх хүртэл үйл ажиллагааг зохицуулахад оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Энэхүү журам нь БОЭТ-ийн яаралтай тусламжийн бүх хэсгийн/ Хүүхдийн яаралтай тусламж, төрөхийн яаралтай тусламж, том хүний яаралтай тусламж/тасгийн эмч, сувилагч тус тасагтай хамтран ажиллах тасаг албадын эмч сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүд даган мөрдөнө.

ГУРАВ.ТОВЧИЛСОН ҮГ

НЭР ТОМЪЁО	ТАЙЛБАР
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЯТТ	Яаралтай тусламжийн тасаг
ЯЭТОЗ	Яаралтай эм тарианы орлого зарлага
АСТ	Амилуулах суурь тусламж
АЛТ	Амилуулах лавшруулсан тусламж
ЗАА	Зохиомол амьсгалын аппарат
ЭСҮ	Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ
ААЗ	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
АШББ	Анхан шатны бичиг баримт
ЭЭТ	Эрчимт эмчилгээний тасаг
ЭТҮХХ	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар
ХСХ	Халдварын сэргийлэлт хяналт
ЭМБО	Эрүүл мэндийн боловсрол олгох

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

3.2.1 ЯТТ-ийн эмч нь үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлээр 2 жил суралцсан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй. Амилуулах суурь болон лавшруулсан тусламж, инвазив болон нонинвазив гардан ажилбаруудыг хийх чадвартай.

3.2.2 ЯТТ-ийн сувилагч нь яаралтай тусламжийн чиглэлээр 3 сар суралцсан, эрэмбэлэн ангилалт болон анхны тусламж үзүүлэх ,амь тэнссэн үеийн тусламжийг багаар үзүүлэхэд чадваржсан ,зөв харилцаа хандлагатай сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхийн мэргэжилтнийг хэлнэ.

3.2.3 Амилуулах хэсэг гэдэг нь амилуулах тусламжийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. /Үүнд:Ханын хүчилтөрөгч, автомат болон гар ажиллагаатай дефибллятор,олон үйлдэлтэй ор, монитор, ЗАА, яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх эм тариа, нэг удаагийн хэрэгсэл, гуурс, амбу маск, бүхий тэргэнцэр/.. гэх мэт багын тусламж үзүүлэхэд тохиромжтой хангалттай зай талбай бүхий хэсгийг хэлнэ

3.2.4 Ажиглах хяналтын өрөө гэдэг нь яаралтай тусламжийн эрэмбэлэн ялгалтын үндсэн зарчмын дагуу үйлчлүүлэгчийн биеийн байдлыг хянах, эмчилгээ оношилгоо хийх 24-72 цагийн дотор шийдвэрлэх шаардлагатай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангагдсан 3-5 ортой байна.

3.2.5 Мэс ажилбарын өрөө нь гэрэлтүүлэг агааржуулалт сайтай, ариун багаж

материал эм, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслээр хангагдсан. Ажилбар хийхэд тохиромжтой зай талбай томтой, ажилбар хийхэд тохиромжтой ор, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалтын кварцаар хангагдсан байх.

3.2.6 Тусгаарлах өрөө нь халдварт өвчин гэж сэжиглэгдсэн, оношлогдсон тохиолдолд тусгаарлан сэргийлэх, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан, агааржуулалтын системтэй, дотроо ариун цэврийн өрөө угаалтууртай, үйлчлүүлэгчдэд зориулсан ор шүүгээ, ширээ сандалтай эрүүл мэндийн ажилтан дуудах дохиололтой байна.

ДӨРӨВ. ИШ ТАТСАН БАРИМТ:

- 4.1 Эрүүл мэндийн тухай хууль
- 4.2 Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- 4.3 ISO 9001:2015 ЧУТ-ны стандарт
- 4.4 Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- 4.5 MNS4621/2008/ стандарт
- 4.6 ЭМС-ын 2021 оны А/814 тоот тушаал
- 4.7 ЭМС-ын 2019 оны А/294 тоот тушаал
- 4.8 ЭМС-ын 2009 оны 388 тоот тушаал
- 4.9 ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал
- 4.10 ЭМС-ын 2019 оны А/538 тоот тушаал
- 4.11 ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаал
- 4.12 Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаал
- 4.13 БОЭТөв-ийн хөдөлмөрийн дотоод журам
- 4.14 БОЭТ-н эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөх журмууд 2012 он
- 4.15 БОЭТ-өөр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, нийтлэг журам
- 4.16 БОЭТөвд амилуулах лавшруулсан тусламж үйлчилгээ үзүүлэх “CODE BLUE”
- 4.17 Америкийн зүрх судасны нийгэмлэгийн Амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх удирдамж 2016,2020 он
- 4.18 Монгол улсын стандарт MNS 6717:2018 Түргэн тусламжийн бүтэц үйл ажиллагаа
- 4.19 Ёс зүйн хэм хэмжээ

ТАВ:ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН МАТРИЦ

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

Албан тушаал Процесс	Тасгийн эрхлэгч	ЯТТ Их эмч	Жижүүр эмч	Жижүүрийн ахлагч эмч	ЯТТ Сувилагч	ЯТТ ахлах сувилагч	Зөвлөх эмч	ЭЭ ДЗ
Үйлчлүүлэгчийг хүлээн авах, эрэмбэлэн ангилах	RACI	RACI	RACI	RACI	RAC	RACI	RCI	CI
Үзлэг оношилгоо, шинжилгээ хийгдэнэ.	CI	RA	RA	CI	RA	RCI	CI	CI

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам

/яаралтай тусламжийн хуудсанд стандарт дагуу бичнэ /								
Шаардлагатай шинжилгээ бүрдүүлнэ. / шинжилгээ авах сорьц өгөх хариу авах /	ACI	RACI	RACI	ACI	RA	ACI	I	I
Амь тэнссэн амилуулах тусламж шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлнэ./CODE BLUE баг идэвхжүүлэх/	RACI	RACI	RACI	RACI	RACI	RACI	RACI	CI
Шаардлагатай эмчилгээ үйлчилгээ үзүүлэх ЭТҮХХалдвар хамгаалал дэглэм баримтлан шаардлагатай ажилбар хийх /ТВГ, уян зүү тавих, зонд, тавих,нугасны ус авах, хэвлий болон цээжний хөндийд гуурс тавих, зохиомол амьсгалын аппарат авах//	RACI	RACI	RACI	RCI	RACI	RACI	CI	CI
Үйлчлүүлэгчийн ар гэрт мэдээлэл өгч, Шаардлагатай тохиолдолд зөвшөөрлийн хуудсыг танилцуулж баталгаажуулах	RACI	RACI	RACI	I	CI	CI	I	I
Нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг хийж дүгнэлт шийдвэрийг гэр бүлийнхэнд танилцуулах	RACI	RACI	RACI	RACI	I	I	RACI	CI
Үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх, ажиглах, буцаах асуудлыг шийдвэрлэх	RA	RA	RA	I	CI	CI	I	I
Нас баралтын тохиолдолд ЭМС-н A/55 тоот тушаалын дагуу	I	AI	AI	I	I	I	I	CI

эмгэг судлалын шинжилгээг хийх. Нас баралтын шалтгааныг тогтоох								
---	--	--	--	--	--	--	--	--

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

5.2 ТӨВИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН МАТРИЦ

тушаал Процесс	Албан	Тасгийн эрхлэгч	103-ийн жижүүр эмч	Жижүүрийн жолооч	Дуудлага зохицуулагч сувилагч	ЯТТ ахлах сувил агч
Дуудлагыг хүлээн авах, эрэмбэлэн ангилах		CI	RACI	CI	RACI	CI
Эмч жолоочид мэдэгдэх / түргэн тусламжийн хуудсанд стандарт дагуу бичнэ /		CI	RACI	RACI	RACI	CI
Шаардлагатай тохиолдолд дуудлага очих хүртэл үзүүлэх тусламжийг зөвлөх					RACI	
Яаралтай дуудлагыг араас нь утсаар эрэмбэлж эмч жолоочид өгөх		CI	RACI	RACI	RACI	CI
Төрөх, Осол гэмтлийн дуудлагад шаардагдах эм эмнэлгийн хэрэгслийг хангах/ төрөхийн бикс,хүзүүний чиг, нуруу, мөчдийн чиг/		CI	RACI	RACI	RACI	CI
Хүнд үйлчлүүлэгч тээвэрлэлтийг 103-ийн их эмч яаралтай тусламжийн тасаг утсаар мэдээлэх		CI	RACI	CI	RACI	CI
Тээвэрлэх боломжгүй зүрх зогсолт зүрх сэргэсний дараах байдал, хүнд хэлбэрийн засагдахгүй бүх шокийн үед талбар дээр мэргэжлийн баг дуудах	RACI		RACI	RACI	CI	CI
Эмнэлэг хүртэлх тусламжийг үзүүлэх			RACI	RACI	CI	CI
103-ийн их эмч шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө авах	RACI		RACI		CI	CI

Гэмт хэргийн шинж чанартай дуудлага /нас баралт, осол гэмтэл, бие махбод болоод сэтгэлзүйн гэмтэл/ 7032102-т мэдээлнэ.	CI	RACI	RACI	RACI	CI
--	----	------	------	------	----

ЗУРГАА : ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСАГТ ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1 ЯТТ нь эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг 24 цагаар багаар үзүүлнэ.
- 6.2 ЯТТ-т эмчлүүлэгч тусламж үйлчилгээ авахаар дараах урсгалаар ирнэ. Үүнд:
 - 6.2.1 Өөрөө ирнэ
 - 6.2.2 Амбулаториос ирнэ
 - 6.2.3 Түргэн тусламжаар эмтэй тээвэрлэгдэж ирнэ
- 6.3 Яаралтай тусламжийн тасаг нь гэсэн утастай байна. Аймгийн 18 сумаас болон бүсийн аймгуудаас тээвэрлэх үедээ тус утас руу эмчлүүлэгчийн бэлэн байдлыг талаар мэдээлж үйлчлүүлэгчийн биеийн байдал, өгсөн мэдээллийн дагуу шаардлагатай баг, эм эмнэлгийн хэрэгсэл, яаралтай тусламжийн орыг бэлдэн үйлчлүүлэгчийг хүлээн авна.
- 6.4 ЯТТ ирсэн эмчлүүлэгчийг эрэмбэлэн ангилахын мэргэжилтэн үйлчлүүлэгчийг хүлээн авч амин үзүүлэлт болон биеийн байдлыг нүдэн баримжаагаар/ анхны мэдрэмжийн үнэлгээ/ үнэлгээ хийж нэн даруй тусламж үйлчилгээ авах үйлчлүүлэгч мөн эсэхийг үнэлнэ.
 - 6.4.1 Нүдэн баримжааны үнэлгээгээр нэн даруй тусламж авах эмчлүүлэгчид дараах орно.
 - 6.4.1.1 Эмчлүүлэгч ухаангүй
 - 6.4.1.2 Эмчлүүлэгч зүрх, амьсгал зогссон
 - 6.4.1.3 Маш хүчтэй өвдөлттэй
 - 6.4.1.4 Эмчлүүлэгч өөрөө явах чадамжгүй, биеийн байдал хүнд
- 6.5 Нэн даруй тусламж үзүүлэх хүнд үйлчлүүлэгч бол үйлчлүүлэгчийн бүртгэл мэдээлэл, эрэмбэлэн ангиллыг зэрэг хийнэ.
- 6.6 Амилуулах тусламж шаардлагатай үед /Blue кодыг идэвхжүүлэх/ журмаа ажиллана.
- 6.7 Эмч анхдагч үнэлгээ хийж оношилгоо шинжилгээ эмчилгээг төлөвлөж яаралтай тусламжийн хуудсанд бичиж тэмдэглэнэ.
- 6.8 Эмчийн бичсэн эмчилгээг сувилагч сувилахуйн MNS2008 4621 стандартын дагуу эмчилгээг хийнэ.
- 6.9 Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг эмч үнэлж амин үзүүлэлт хянах хугацааг тогтож сувилагчид мэдээлнэ, сувилагч эмчийн заасан хугацаанд болон өөрийн үнэлгээний дагуу амин үзүүлэлтийг хэмжиж, сувилахуйн үнэлгээнүүдийг хийнэ
- 6.10 Эмчлүүлэгчээс дараах тохиолдолд зөвшөөрөл заавал авч, зөвшөөрлийн хуудас бөглүүлсэн байна.
 - 6.10.1 Биед нэвтрэлтэй инвазив бүх төрлийн ажилбаруудын үед
 - 6.10.2 Эмчилгээ үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд
 - 6.10.3 Амилуулах тусламж үзүүлэх үед
 - 6.10.4 Эмч гарч болох хүндрэл эрсдэл, үр дагаврын талаар танилцуулна.

- 6.10.5 Зөвшөөрлийн хуудсанд тэмдэглэгээ хийж ар гэр болон өөрөө гарын үсэг суруулж баталгаажуулна.
- 6.11 /ЭМС-ын А/611 тоот тушаалын дагуу холбогдох маягтаар авна./
- 6.12 Яаралтай тусламжийн эмч эмчлүүлэгчид үзлэг хийнэ. Үзлэг эмчилгээг хийхдээ:
- 6.12.1 **Эрэмбэлэх өрөөнд:** Эрсдэлийн түвшин өндөр 1,2 дугаар эрэмбийн анхны үзлэгийг эрэмбийн өрөөнд хийж, цаашид асуудлыг шийднэ.
- 6.12.2 **Үзлэгийн өрөөнд:** Эрсдэлийн түвшин бага 3,4,5 дугаар эрэмбийн эмчлүүлэгчийг цагийг эрэмбийн дарааллын дагуу үзүүлнэ.
- 6.12.3 **Ажиглалт эмчилгээний өрөөнд:** Үргэлжилсэн эмчилгээ хяналт хийгдэх шаардлагатай эмчлүүлэгчийг үзнэ.
- 6.12.4 **Тусгаарлах өрөөнд:** Халдварын сэжигтэй эмчлүүлэгчийг үзнэ.
- 6.13 Яаралтай тусламжийн эмч үзлэг хийсний дараа
- 6.13.1 Цус болон багажийн шинжилгээ төлөвлөх
- 6.13.2 Ажиглалт эмчилгээний өрөөнд эмчилгээ хяналт хийх
- 6.13.3 Нарийн мэргэжлийн эмчийг дуудах
- 6.13.4 Яаралтай тусламж үйлчилгээг дуусгавар болгох шийдвэрүүдийг гаргана.
- 6.14 **Цус болон багажийн шинжилгээ төлөвлөх.**
- 6.14.1 Яаралтай тусламжийн эмчийн захиалгаар цусны шинжилгээ авна.
- 6.14.2 Яаралтай тусламжийн эмч болон дуудагдан ирсэн нарийн мэргэжлийн эмчийн заавраар багажийн шинжилгээний захиалга eHealth-д орсны дараа хариуцсан сувилагч багажийн шинжилгээ хийлгэнэ. Эмчлүүлэгч багажийн шинжилгээ хийлгэхдээ дараах зүйлсийг анхаарна.
- 6.14.2.1 Өөртөө үйлчлэгч чадвартай эмчлүүлэгчийг багажийн шинжилгээнд харгалзах хүнгүй явуулна
- 6.14.2.2 Эмчлүүлэгч өөртөө үйлчлэх чадвартай хэдий ч биеийн байдал тогтвортой бол шинжилгээнд ар гэрийн хяналтад явуулна
- 6.14.2.3 Эмчлүүлэгч өөрөө явах явах чадваргүй, биеийн байдал тогтвортой бол эмчлүүлэгчийг хариуцаж байгаа сувилагч авч явна.
- 6.14.2.4 Өндөр хяналт шаардсан хүнд эмчлүүлэгчийн шинжилгээний явцыг ЯТ эмч хариуцна
- 6.14.2.5 Багажийн шинжилгээнд тээвэрлэлт хийх боломжгүй эсвэл эрсдэл өндөртэй бол орны хажууд хийгдэх боломжтой шинжилгээг бүрдүүлнэ.
- 6.14.3 Ажиглах хэсэгт бэлтгэл шаардсан шинжилгээнд эмчлүүлэгчийг бэлдэх ба ажиглалт эмчилгээний сувилагч хариуцна. /Улаан хоолой ходоод, бүдүүн гэдэсний дуран, өндөр хяналт шаардлагатай хүн тодосгогчтой компьютер томография, Ангиография гэх мэт
- 6.14.4 Төлбөртэй тусламж үйлчилгээг авах шаардлагатай үед төлбөртэй тусламж үйлчилгээний журмыг баримтлан ажиллана.
- 6.15 Ажиглалт эмчилгээний өрөөнд эмчилгээний хяналт хийх:**
- 6.15.1 Яаралтай тусламжийн эмчийн зааврын дагуу эмчилгээг хийн, эрчимт эмчилгээний хуудсаар амин үзүүлэлтийг цаг дутам хянаана. Тус хэсэгт сувилагч тухайн эмчлүүлэгчийг хариуцан ажиллана.
- 6.15.2 Яаралтай тусламжийн тасагт эмчлүүлэгчийг 6 цаг хүртэлх тусламж

үйлчилгээг авна. Эмчлүүлэгчийн эмчилгээ үйлчилгээний цаашдын шийдвэрийг энэ хугацаанд багтаан гаргах ба 6 цагаас хойш шийдвэр гарахгүй бол яаралтай тусламж эрчимт эмчилгээний мэргэжлийн багын ахлагч, зөвлөх эмч болон тасгийн эрхлэгч нарийг оролцуулан хамтарсан үзлэг хийж шийдвэрлэнэ. Хамтарсан үзлэгийн баг шаардлагатай гэвэл эмчилгээ эрхэлсэн дэд захирлыг байлцуулан шийдвэрлэнэ.

6.16 Нас барсан үед :Үйлчлүүлэгчийн нэр хаяг тодорхойгүй өөрөө мэдүүлэг өгөх боломжгүй эмнэлэгт ирээд нас барсан тохиолдолд цагдаагийн байгууллагат мэдээлж шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд оруулна. Ажлын цагаар нас барсан тохиолдолд тасгийн эрхлэгчд танилцуулж ЭЭДЗахиралаар, ажлын бус болон амралтын өдрүүдэд жижүүрийн ахлагч эмч ЭЭДЗахиралд мэдээлж эмгэг анатомийн задлан шинжилгээнд оруулна.

6.17 Тусгаарлах өрөөний эмчилгээний хяналт хийх

6.17.1 Халдварын сэжигтэй бүх тохиолдол

6.17.2 Олон эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвартай үйлчлүүлэгчийг байршуулах (дангаар хэрэглэх суултуур, угаалтуур, ванн) өрөө

6.17.3 2019оны А/537тушаалын хавсралт 9-ыг даган мөрдөнө

6.18 Төрөлжсөн болон үндсэн нарийн мэргэжлийн эмчийг дуудах:

6.18.1 Яаралтай тусламжийн шийдвэрээр шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчтэй хамтран үзлэг хийнэ. Нарийн мэргэжлийн эмч дуудахдаа

6.18.1.1 Ehealth эмч дуудах хэсэгт захиалга оруулна

6.18.1.2 Эмчлүүлэгчийг хариуцаж байгаа сувилагчид мэдэгдэнэ.

6.18.1.3 Сувилагч дотоод утсаар нарийн мэргэжлийн эмчийг дуудна.

Дуудсан цаг бүртгэж авна

6.18.2 Дуудагдсан эмч ЯТТ-т 30 минутын дотор очно.

6.18.2.1 Ажлын цагаар тасгийн эрхлэгч, мэргэжлийн багын ахлагч

6.18.2.2 Ажлын бус цагаар жижүүр эмч ЯТТ-т ирнэ.

6.18.3 Нарийн мэргэжлийн эмчид ЯТ эмч эмчлүүлэгчийн мэдээллийг ISBAR загвараар өгнө. ЯТ-т эмч завгүй тохиолдолд хариуцсан сувилагч шинжилгээ болон бусад мэдээллийг дуудагдан ирсэн эмчид ISBAR загвараар өгнө.

6.18.4 Эмчлүүлэгчийн цаашдын эмчилгээ үйлчилгээг ЯТ-ийн эмч дангаар, зарим тохиолдолд дуудагдан ирсэн эмч болон ЯТ эмч хамт шийднэ.

6.18.5 Дуудагдан ирсэн эмч ЯТ эмчид мэдэгдэлгүй эмчилгээг өөрчлөх нэмэх болон хасхыг хориглоно.

6.18.6 Дуудагдаж ирсэн эмч үзлэгийг дүгнэлт саналыг эмчийн тэмдэглэл хэсэгт тэмдэглэж үлдээнэ.

6.19 Яаралтай тусламж үйлчилгээг дуусгах

6.19.1 Яаралтай тусламж үйлчилгээг дараах байдлаар дуусгавар болгон шийдвэрлэнэ

6.19.2 Гэрт буцаах:

6.19.2.1 Яаралтай тусламжийн эмчийн шийдвэрээр буцна.

6.19.2.2 Нарийн мэргэжлийн эмчийн шийдвэрээр буцна. / үзлэг , шинжилгээ, эмчилгээ хийж түүндээ үндэслэн дууссан цагийг тэмдэглэн гэрт нь буцаана./

6.19.3 Амбулаториор үзүүлэхээр буцаах:

6.19.3.1 Амбулаториор үзүүлэх шаардлагатай эргэлзээтэй болон

биеийн байдал тогтвортой ч цаашид онош тогтоох, эмчилгээ шаардлагатай эмчлүүлэгчийг илгээнэ

6.19.4 Бусад эмнэлэг рүү илгээх ба шилжүүлэх

6.19.4.1 Эмчлүүлэгчийн биеийн байдал тогтвортой: Бүсийн оношилгоо эмчилгээний хүрээнд тусламж үзүүлэх боломжгүй тохиолдолд хамтарсан багын шийдвэрээр Эмчилгээ эрхэлсэн дэд захиралд мэдэгдэж лавлагаа шатлал илгээх, сум, өрхийн түвшинд хянагдах шаардлагатай эмчлүүлэгчийг харьяа эмнэлгийн хяналтад илгээнэ.

6.19.4.2 Эмчлүүлэгч биеийн байдал тогтворгүй: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ЯТ хуудаст шилжүүлж байгаа эмнэлгийг бичиж, цагийг хааснаар ЯТ үйлчилгээ дуусгавар болгоно, шаардлагатай бичиг баримтыг хавсаргана

6.19.4.3 Тээвэрлэхээс өмнө эмчлүүлэгчийн биеийн байдал тогтворжуулсан байна.

6.19.4.4 Тээвэрлэхдээ зохих бэлтгэлийг ханган амилуулах тусламж үзүүлэх чадвартай эмч эмчлүүлэгчийг эмнэлэг хооронд тээвэрлэн хүлээлгэн өгнө.

6.19.5 Хэвтэн эмчлүүлэх тасагт хэвтүүлэх:

6.19.5.1 Хэвтэн эмчлүүлэн тасагт тус тасгаас дуудагдан ирсэн эмчийн шийдвэрээр орын захиалга хийнэ.

6.19.5.2 Өвчний түүх нээгдсэнээр Яаралтай тусламжийн хуудас хаагдаж яаралтай тусламж үйлчилгээ дуусгавар болно.

6.19.5.3 Тасаг хооронд тээвэрлэх үед “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” мөрдөн ажиллана.

6.20 Нас баралтын үед:

6.20.1 Яаралтай тусламжийн тасагт нас барсан тохиолдолд: **“Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний түгээмэл үйлдэл MNS7015:2023”** стандартыг мөрдөн ажиллана

6.20.2 Нас барагчид халдварын эрсдэлгүй тохиолдолд сувилагч дараах зүйлсийг хийнэ:

6.20.2.1 Биед байрлуулсан гуурс, катетрыг авна./ эмгэг судлалын шинжилгээний ач холбогдолтой зарим тохиолдлуудад авахгүй /

6.20.2.2 Биеийг бүхэлд нь цэвэрлэнэ.

6.20.2.3 Гар, хөлийг биеийн дагуу байрлуулна.

6.20.2.4 Цагаан хэрэглэлээр нүүрийг ил гарган биеийг орооно.

6.20.2.5 Нас барсан эмчлүүлэгчтэй ар гэрийнхийг хамт байх боломж Олгоно.

6.20.2.6 Бусад эмчлүүлэгчид саад бололгүй шашны зан үйл үйлдэхийг зөвшөөрнө. Эмнэлгийн зүгээс боломжтой бүх туслалцааг үзүүлнэ.

6.20.3 Дараах тохиолдолд цогцсыг задлан шинжилгээнд илгээхдээ “Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний түгээмэл үйлдэл MNS7015:2023” стандартын мөрдөнө.

6.20.4 Дараах тохиолдолд цогцсыг ар гэрт нь хүлээлгэн өгнө:

6.20.4.1 Тодорхой ястнуудын зүгээс шашин болон ёс заншилтай холбоотой байдал үүссэн

6.20.4.2 Гэр бүлийн гишүүд задлан шинжилгээнээс татгалзсан

хүсэлт гаргаж, эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар баталгаажсан.

6.20.5 Нас барсны дараа тасагт 2 цаг байлгаад Эмгэг судлалын эмч, эмгэг судлалын техникчид мэдэгдэн цогцсыг шилжүүлнэ. Эмчлэгч эмч нь яаралтай тусламжийн хуудсанд тэмдэглэл хөтлөн эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар батлуулан эмгэг судлаач эмчид өгнө.

6.21 ЯТТ тасагт жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн эмч сувилагч жижүүр хүлээлцэх

6.21.4 ЯТТ Эмч , сувилагч нар өглөө 8:40-09:00-н хооронд ээлж хүлээлцэнэ.

6.21.5 ЯТТ-т ирсэн эмчлүүлэгчийн бүх мэдээллийг ehealth программд бүрэн шивж оруулсан байна.

6.21.6 Жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн эмч яаралтай тусламжийн эмчид өвчтөний биеийн байдлыг танилцуулан хүлээлгэж өгнө.

6.21.7 Ажиглах хяналтын хэсэгт өвчтөн хянаж оношилгоо эмчилгээ хийж хоносон тохиолдолд өвчтөний биеийн байдлыг эрчимт эмчилгээний хуудсаар хянаж, шингэний балансыг хянаж гарсан өөрчлөлтүүдийг эмч эмчид, сувилагч сувилагчид танилцуулна .

6.21.8 Эм тарианы орлого зарлагыг бүрэн тоолж хүлээлцэх, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хүлээлцэнэ.

6.21.9 Тоног төхөөрөмжид эвдрэл үүсэн, алга болсон тохиолдолд тухайн ж ижүүрт хоносон сувилагч хариуцна.

6.21.10 Жижүүрт хоносон ятт-н сувилагч, диспечер сувилагч, 103-ийн эмч нар нар ятт-ийн эмч болон САЗ-д мэдээгээ өгч танилцуулна.

6.21.11 Ээлж хүлээлцсэн байдлыг тэмдэглэх дэвтэр гарган алдаа дутагдал, тулгамдаж буй асуудал, цаашид тулгамдаж буй асуудал цаашид шийдвэрлэх арга зам, шийдвэр, санал хүсэлтийг дотоод хяналтын дэвтэр бичиж Тасгийн эрхлэгч, САЗ-д жижүүр хүлээлцсэн эмч танилцуулах.

ДОЛОО: ЯТТ-ИЙН ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Яаралтай тусламжийн тасгийн эмч мэргэжилтнүүд болон бусад үйл ажиллагаанд оролцох шаардлагатай эмч мэргэжилтнүүд дараах үүрэгтэй. Үүнд:

7.1 Зөвлөх эмчийн үүрэг:

7.1.1 БОЭТ-ийн тасгийн нэгжүүдэд эмчлэгдэж буй биеийн байдал хүнд үйлчлүүлэгчид хамтарсан үзлэг хийж, эмчилгээ , оношилгоо асуудлыг шийдвэрлэнэ.

7.1.2 Мэргэжлийн багийн хурлыг улирал тутамд зохион байгуулж, хурлын үйл ажиллагааг удирдана

7.1.3 Яаралтай тусламжийн тасагт байгаа үйлчлүүлэгчид тасгийн эмч нарын тойрон болон хамтарсан үзлэгийг хийж удирдана.

7.1.4 Ховор тохиолдол, шинэ технологи болон онц хүнд байдлаас амь насыг аварсан тохиолдлуудыг зөвлөх эмчийн багаар хянан хэлэлцүүлнэ.

7.1.5 Нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан болон тойрон үзлэг хийж дүгнэлт шийдвэрийг гэр бүлийнхэнд танилцуулах

7.1.6 Тасгийн эмч нарыг тасралтгүй сургалтад хамрагдах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, бие даан мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

7.1.7 Бусад

7.2 Тасгийн эрхлэгч эмчийн үүрэг

- 7.2.1 Байгууллагатай үр дүнгийн гэрээ хийж үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажиллах
- 7.2.2 ЯТТасгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хянах
- 7.2.3 Тасгийн халдварын сэргийлэлтийн үйл ажиллагаа, чанар аюулгүй байдлаар хамтарч төлөвлөгөө гаргаж, хянаж ажиллах.
- 7.2.4 Тасгийн эрхлэгчийн тойрон үзлэгийг 7 хоногт нэг удаа зохион байгуулж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулах, тодорхой ажлыг зохион байгуулах
- 7.2.5 Эмч, ажилчдын ажлыг сар бүр ахлах сувилагчтай хамтран дүгнэх, шагнал урамшуулалд тодорхойлох, санал дэвшүүлэх
- 7.2.6 Ховор тохиолдол, шинэ технологи болон онц хүнд байдлаас амь насыг аварсан тохиолдлуудыг бүртгэж мэдээлнэ.
- 7.2.7 БОЭТ-ийн хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллана.
- 7.2.8 Тасгийн эмнэл зүй болон орчны эрсдэлийг үнэлж чанар аюулгүй байдлын албатай хамтарч ажиллана.
- 7.2.9 Тасгийн ажилчдын биеийн эрүүл мэндийн байдал болон нийгмийн эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулдаг байх.
- 7.2.10 Тасгийн үзүүлэлтээр судалгаа хийж чанарын үзүүлэлт болон нэвтрүүлэх шинэ технологи санаачилдаг байх
- 7.2.11** Тохиолдол гарсан үед мэдээлэх, хариу арга хэмжээ авах зэрэгт ЭМТҮЧАБАлбатай хамтарч ажиллана
- 7.3 Яаралтай тусламжийн эмчийн үүрэг**
- 7.3.1 Үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилалтын дагуу тусламж үзүүлж амьсгал, цус эргэлтийн байдлыг үнэлж хянана.
- 7.3.2 Үйлчлүүлэгчдэд бүрэн үзлэг хийж яаралтай тусламжийн хуудсыг бүрэн хөтөлж баримтжуулна.
- 7.3.3 Шаардлагатай шинжилгээг бүрдүүлж, нэмэлт ажилбарыг төлөвлөж гүйцэтгэнэ.
- 7.3.4 Үйлчлүүлэгчийн эмчилгээг хянан сувилагчид зааварчилгаа өгч удирдан ажиллана.
- 7.3.5 Халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, сувилагч, туслах сувилагч нарт хяналт тавьж ажиллана
- 7.3.6 Үйлчлүүлэгчийн эмчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагатай бол нарийн мэргэжлийн эмч, болон зөвлөх эмчтэй зөвшилцсөний дараа эцсийн шийдвэрийг гаргана.
- 7.3.7 Жижүүр хуваарийн дагуу ээлжээр ажиллана.
- 7.3.8 Үйлчлүүлэгчид ЭТҮХХ шинж тэмдгийг тандан шаардлагатай хариу арга хэмжээ авна.
- 7.3.9 Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгнө.
- 7.3.10 Үйлчлүүлэгчийг жижүүрийн эмчид биечлэн хүлээлцэнэ.
- 7.3.11 Үйлчлүүлэгчийн онош тодруулах шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн зөвлөх эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийнэ
- 7.3.12 Төрөлжсөн мэргэжлийн зөвлөх эмч нарын хамтарсан зөвлөгөөн эцсийн дүгнэлтийг гаргаж шийдвэрлэнэ.

7.3.13 Тохиолдол гарсан үед мэдээлэх, хариу арга хэмжээ авах зэрэгт ЭМТҮЧАБАлбатай хамтарч ажиллана

7.3.14 Бусад

7.4 Түргэн тусламжийн эмчийн үүрэг:

7.4.1 Өвчний биеийн байдлыг зөв үнэлэх тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх

7.4.2 Талбар дээрх арга хэмжээг хурдан шуурхай зөв тусламж үзүүлэх

7.4.3 Амилуулах суурь тусламж үзүүлэх

7.4.4 Эмнэлэг хүртэлх тусламж үзүүлэх.

7.4.5 Үйлчлүүлэгч амь нас эрүүл мэндэд шууд аюул учрах эрсдэлтэй тохиолдолд яаралтай тусламжийн тасагт тээвэрлэх, урьдчилан мэдээлэх, бэлэн байдлыг хангуулж гараас гарт хүлээлгэн өгнө.

7.4.6 Түргэн тусламжийн үйлчилгээнд холбогдох баримт бичиг хяналтын хуудсыг бүрэн хөтөлсөн байна.

7.4.7 Шаардлагатай эм тарианы бэлэн байдлыг ханган ажиллах.

7.4.8 Гэмт хэргийн шинж чанартай бүх дуудлагыг цагдаагийн байгууллагад мэдээлэх

7.4.9 Тохиолдол гарсан үед мэдээлэх, хариу арга хэмжээ авах зэрэгт ЭМТҮЧАБАлбатай хамтарч ажиллана

7.4.10 Шаардлагатай тохиолдолд талбарт мэргэжлийн баг дуудаж тусламж үзүүлэх шийдвэрийг гаргах. Үүнд:

7.4.10.1 Тээвэрлэх үед амь эрсдэх байдал үүсэх байдал бүхий амь тэнссэн байдалд хамаарал бүхий мэргэжлийн эмчийг талбарт ирүүлж хамтарч тусламж үзүүлэх

7.4.10.2 Талбарт тусламж үзүүлэхэд эмч мэргэжилтэн хүрэлцэхгүй олон тооны болон үй олноор өртсөн гэмтэл осол байдал буюу гамшгийн нөхцөлд байдал

7.4.10.3 Эмчийн биеийн байдалд тусламж үзүүлэх боломжгүй эрүүл мэндийн шалтгаант нөхцөл байдал

7.5 Ахлах сувилагчийн үүрэг

7.5.1 Сувилагч нарын ажил үүрэг, амралтын хуваарь, гарган удирдлагаар хангана.

7.5.2 Сувилахуйн тусламж үйлчилгээг стандартын дагуу гүйцэтгэхэд хяналт тавьж сувилагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж аргазүйн зөвлөмж өгнө.

7.5.3 Яаралтай тусламжийн тасгийн сувилахуйн эрсдэлийн үнэлгээг жил тутамд сувилахуйн багаар хийж эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг тооцно.

8 Сувилагч нарт ААЗааварчилгааг өглөө бүр өгч баталгаажуулна.

8.1.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн нөөцийн бүрдэл ашиглалтад хяналт тавина.

8.1.2 Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хянаж, төлөвлөсний дагуу буюу шаардлагатай үед засвар үйлчилгээ хийлгэх

8.1.3 Шинэ хэрэгцээ шаардлага болон хөгжлийн дагуу боловсон хүчнийг сонгоход оролцоно.

8.1.4 Сувилагч нарын ур чадварыг сайжруулах, шинэ ажилтан сургаж

дадлагажуулах ажлыг зохион байгуулна.

8.1.5 Яаралтай тусламжийн тасгийн ХСХ ажилтны үүргийг гүйцэтгэнэ.

8.1.6 Сувилагч нарны ур чадварт үнэлгээ дүгнэлт хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж харьяа албанд хүсэлт гаргах, тасгийн сувилагч нарын ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд анхаарал хандуулна.

8.1.7 Тохиолдол гарсан үед мэдээлэх, хариу арга хэмжээ авах зэрэгт ЭМТҮЧАБ Албатай хамтарч ажиллана

8.1.8 Бусад

8.2 ЯТТ-ийн сувилагчийн үүрэг:

8.2.1 Ажлын цаг эхлэхээс 20 минутын өмнө ирж ээлж хүлээлцэнэ.

8.2.2 Тухайн өдрийн жижүүр эмч нарын нэрсийг яаралтай тусламжийн үүдэнд байршуулсан байна.

8.2.3 Үйлчлүүлэгчид анхны үзлэгийг хийж эрэмбэлэн ялгана үйлчлүүлэгчийг бүртгэнэ

8.2.4 ЯТ-ын хуудсыг гаргацтай, үнэн зөв, гүйцэд бөглөж, эрэмбийн өнгийн хавтсанд хийж, үйлчлүүлэгчид эрэмбэлэн ялгалтын тэмдгийг бугуйнд нь зүүж өгнө.

8.2.5 Анхны үзлэг хийн цаашид үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд хохирол учрахааргүй ногоон цагаанаар эрэмбэлэгдсэн үйлчлүүлэгчийг эмчид үзүүлж шийдвэрлэнэ /харьяа эмнэлэг, амбулатори, гэр лүү нь буцаах гэх мэт/

8.2.6 Үйлчлүүлэгч, түүний ар гэрт тайлбар өгөх

8.2.7 Хүлээлгийн өрөөний үйлчлүүлэгч, ар гэрийг зохион байгуулах

8.2.8 Нэр хаяг нь тодорхойгүй үйлчлүүлэгчийн эд зүйлсийг харуул хамгаалалтын ажилтан хөндлөнгийн гэрчийг байлцуулан бүртгэн шүүгээнд хадгалж, хүлээлцэж, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана

8.2.9 Ажлын бус цагаар эмнэлэгт хэвтэх үйлчлүүлэгчийн өвчний түүх нээнэ.

8.2.10 Шинжилгээ, сорьц авах.

8.2.11 Ээлжийн мэдээ гаргах

8.2.12 Нөөцийн эм тариа захиалах, хэрэглэсэн эмийн зарлага гаргаж бодох

8.2.13 Камерын ажиллагааг хүлээлцэх

8.2.14 Дотуур болон гадуур утасны дуудлагад хариу өгөх

8.2.15 Шинжилгээнд үйлчлүүлэгчийг зөөвөрлөх

8.2.16 Эмнэлгийн хог хаягдлыг ангилан ялгаж тушаах

8.2.17 Асгарсан болон өвчтөнөөс гарсан биологийн шингэн, халдвартай эд зүйлсийг цэвэрлэх

8.2.18 Хэрэглэгдсэн бохир багаж материалд анхны угаалга хийж ариутгалд өгөх

8.2.19 Үйлчлүүлэгчдэд ЭМБО-х сургалт явуулах,

8.3 103-ийн сувилагчийн үүрэг, хариуцлага

8.3.1 Утсаар мэдээлэл өгөх журмыг мөрдөн, өгсөн дуудлага бүрийг хүлээн авч хариуцлагатай хандах

8.3.2 Болзошгүй халдварт өвчнүүдийн үед бэлэн байдлыг хангаж, эм

тарианы хүчинтэй хугацааг шалгаж хянах.

8.3.3 Төрөхийн дуудлага болон гэмтлийн дуудлаганы бикс, бэлэн байдлын хангаж, тухайн дуудлага бүрт жижүүр эмчид өгч явуулах

8.3.4 Ойр болон алсын дуудлагын хүлээн авч ЭЭОрлогч даргад танилцуулан цагт нь түргэн шуурхай гаргах

8.3.5 Эмнэлгийн анхны тусламжийн отрядын үед бэлэн байдлыг ханган, БОЭТөвийн захирлын а/294 тушаалын дагуу, эм тарианы хүчинтэй хугацааг хянаж ажиллах

8.3.6 Үйлчлүүлэгчийн түүхийг үнэн зөв гаргацтай бичиж, хурдан шуурхай нээж өгч, үйлчлэх

8.3.7 Эмийн захиалгыг стандартын дагуу хийх

8.3.8 Яаралтай тусламжийн эм тариа болон төвийн дуудлагын эм тарианы бэлэн байдлыг ханган, хүчинтэй хугацаа сери дугаарыг хянах

8.3.9 10Зийн дуудлагын үед хэрэглэгдэх бүх зүйлийг эмчид бэлдэж өгөх, чиг, бэхэлгээ, болон багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, бэлэн байдлыг хангаж ажиллах, алга болохоор сэргийлэх, жижүүр хоорондоо хүлээлцэж ажиллах

8.3.10 Алсын дуудлагаар явж байгаа багт аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын бус цагаар өгч гарын үсгээр баталгаажуулах

8.3.11 Дотоод богино долгионы станцыг жижүүр эмч нарт хүлээлгэн өгч хүлээн авах

8.3.12 Анхан шатны бичиг баримтыг үнэн зөв хөтлөх

8.4 103-ийн жолоочийн үүрэг, хариуцлага

8.4.1 Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, хянах

8.4.2 Дуудлагын баг бүрэлдэхүүнийг цуглуулах

8.4.3 Техникийн засвар үйлчилгээг хангах

8.4.4 Замын хуудас бөглөж санхүү албатай хамтарч ажиллах

8.4.5 Авто машины цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх

8.4.6 Дуудлага гүйцэтгэхэд бэлэн байдлыг хангаж ажиллах

8.4.7 Амилуулах суурь тусламж үзүүлэх мэдлэг чадвартай байх, эмчтэй хамтрагч тусламж үзүүлэх туслах.

8.4.8 Аюулгүй замаар өвчтөн тээвэрлэх, хаяг байршлыг тодорхой мэддэг байх.

8.4.9 Машины дуут дохио, JPS-ийг суулгасан ажиллуулах мэдлэгтэй

8.4.10 Аюулгүй ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллах, / хүрз, галын хор, ослын тэмдэг, тороос,

8.4.11 Өвчтөнд шаардлагатай зүйлсийг бэлдэж

8.4.12 хангах/Зөөврийн хүчилтөрөгч, дулаан хөнжил, чиг, дамнуурга, /

НАЙМ. ДУУДЛАГААР ТӨВИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ХИЙГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвийн дуудлагыг гүйцэтгэхэд дараах үйл ажиллагаануудыг баримтална. Алсын дуудлага нь “Алсын дуудлага зохицуулах журам”-ыг мөрдөнө.

8.1 Жирэмслэлт, төрөлт, цочмог эмгэг, байгалийн гэнэтийн аюул, осол гэмтэл,

хордлогод нэрвэгсдэд, хүний амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, эмчлэх, түүнийг сэхээн амьдруулах, хүндрэлээс сэргийлэх, аймаг болон сум сумын эмнэлэгт эмчлүүлж буй хүн амд нарийн мэргэжлийн чиглэлээр яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээнүүдийг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

8.2 Ойрын түргэн тусламжийн үйлчилгээг аймгийн төвөөс 0-25 км-т яаралтай түргэн тусламжийн буюу 103-н эмч, жолооч гүйцэтгэнэ.

8.3 Ойрын алсын түргэн тусламжийн үйлчилгээг аймгийн төвөөс 25-75 км-т яаралтай түргэн тусламжийн буюу 103-н эмч, жолооч гүйцэтгэнэ.

8.4 Төвийн дуудлага хүлээн авах

8.4.1 Яаралтай түргэн тусламжийн тасагт ирсэн иргэний болон сум, өрхийн эмнэлгээс ирсэн дуудлагыг дуудлага зохицуулагч хүлээн авна.

8.4.2 Дуудлага хүлээн авагч нь утсан харилцааны стандартын дагуу дуудлагыг авч мэдээллийг ЭМС-ын 2019 оны 611 тоот тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-23Б, СТ-23А маягтууд болон дуудлага хүлээн авах ба гаргах журналуудыг цаг тухайд нь үнэн зөв бүрэн гүйцэд хөтөлнө.

8.4.3 Түргэн тусламжийн эмч жолоочид мэдээлж, 10 минутын дотор дуудлагыг гаргана./ Эмч, жолооч дуудлагад явсан тохиолдолд утсаар араас нь мэдээлнэ/

8.4.4 Дуудлага очих хүртэл дуудлага зохицуулагч шаардлагатай тусламж зөвлөгөөг өгнө.

8.4.5 Алсын түргэн тусламжийн дуудлагыг Эмчилгээ эрхэлсэн дэд захиралд танилцуулж, дуудлагыг явах эсэхийг шийдвэрлэнэ. /Шаардлагатай тохиолдолд зөвлөх эмчийг дуудлага өгсөн эмчтэй холбогдуулж дуудлага очих хүртэлх хугацаанд хийх эмчилгээний зөвлөгөө өгүүлнэ./

8.4.6 Дуудлагад гаргахын өмнө жижүүр сувилагч дуудлагад явах эмч болон багийнханд “Аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулж гаргана

8.4.7 Дуудлагаар үйлчлэгч эмч, мэргэжилтэн нь эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг холбогдох эмнэл зүйн удирдамжийн дагуу цогцоор үзүүлнэ.

8.4.8 Дуудлагад явсан эмч, мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ хэрхэн хүргэсэн талаар дуудлагын хуудсанд тодорхой тэмдэглэж ЭЭДЗ-д танилцуулна.

8.4.9 Алсын дуудлагад үйлчилсэн /сумын төвөөс хол / тохиолдолд эмч яаралтай тусламжийн томилолтын хуудсыг / дуудлагад гүйцэтгэсэн ажил үүргийн талаарх мэдээллийг/ бүрэн гүйцэт, үнэн зөв бичиж, эмчилгээ эрхэлсэн орлогчид танилцуулна. Эмчилгээ эрхэлсэн орлогч гарын үсэг зурж баталгаажуулна.

8.4.10 Ерөнхий санхүүчийн цохолтоор алсын болон ойрын дуудлагад явах автомашины шатахуун, тослох материалыг тарифт заасны дагуу бүрэн олгож бэлэн байдлыг жолооч хангана.

8.4.11 Жолооч дах, дэгтий, эсгий гутал, хүрз, олс татлага, насос, демократ, нөөц дугуй зэрэг автомашины байнгын бэлэн байдлыг хангаж ажиллана.

ЁС. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АР ГЭРИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

9.1 Яаралтай тусламжийн тасагт өвчтөн үзүүлж байгаа бол үйлчлүүлэгчийн

биеийн байдал тогтвортой үед ар гэр хүлээлгийн танхимд хүлээнэ.

9.2 Эргэлтээр орохдоо гадуур хувцас тайлж, нэг удаагийн халад өмсөж, гутлын улавч өмсөж орно уу

9.3 Үйлчлүүлэгчийн биеийн байдлын тухай мэдээллийг зөвхөн эмчлэгч эмчээс авна.

9.4 Үйлчлүүлэгчийн биеийн байдал маш хүнд, өвчний эцсийн шатанд байгаа тохиолдолд гэр бүл, төрөл төрөгсдөөс нэг хүнийг оруулж хамт байх боломжийг олгоно.

9.5 Сахиурын үүрэг гүйцэтгэж байхдаа үнэт эдлэл, их хэмжээний мөнгө, хурц ирмэгтэй эд зүйлсийг биедээ хадгалахгүй, тэсэрч дэлбэрэх зүйлсийг эмнэлэгт авч орохгүй байх.

9.6 Сахиур нь эмчилгээ үйлчилгээтэй холбоотой санал бодлоо илэрхийлж, эмч сувилагч, бусад үйлчлүүлэгчтэй зөв боловсон харилцана.

9.7 Эмч ажилтнуудын ажилд саад учруулалгүйгээр өвчтөний талаар мэдээлэл авах эрхтэй.

9.8 Эмнэлгийн болон тасгийн дотоод журмыг мөрдүүлэх талаар тавьсан эмч, сувилагчийн шаардлагыг хүлээн авч мөрдөнө.

9.9 Эмч ажилтнуудын бие болоод сэтгэл зүйн дарамт үзүүлэхийг хориглоно.

9.10 **Хориглох зүйл:** Тасаг дотор гадуур хувцас, гуталтай орох, арц, хүж асаах утсаар ярих, өвчтөний дэргэд хоол идэх, эмчийн зөвшөөрөлгүй хөндлөнгийн хүн оруулах /лам, бөө, өөр эмч г.м/ -ыг хориглоно.

9.11 Эмчийн заалтаас гадуур, эмчтэй зөвлөлдөхгүйгээр эм тариа хэрэглэх, яаралтай тусламжийн хуудсыг зөвшөөрөлгүй авч явах, утсаар бичлэг хийх, зураг авах зэргийг хатуу хориглоно.

9.12 Яаралтай тусламжийн тасгийн хүлээн авах дотор утсаар ярихыг хориглоно.

АРВАН . ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АР ГЭРТ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

10.1 Эрэмбийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг хүлээн авч эрэмбэлэн ангилалт хийж, хүлээгдэх хугацааны талаар өөрт болон ар гэрт мэдээлэл өгнө.

10.2 ЯТТасагын их эмч оношилгоо, ялган оношилгоо, шинжилгээ, эмчилгээний талаар мэдээлэл өгнө.

10.3 Тухайн үйлчлүүлэгчийн биеийн байдлын талаар тухай бүрд мэдээлэл өгнө.

10.4 Хийлгэсэн эмчилгээний үр дүнг өөрт болон ар гэрийнхэнд мэдээлэх

10.5 Эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой эмчилгээ оношилгоонд доголдол гарсан тохиолдолд мэдээлэл өгнө.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

11.1 ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭРХЛЭГЧИЙН ХАРИУЦЛАГА

11.1.1 Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт заасан үүрэг биелүүлээгүй байгууллагын дотоод журам зөрчсөн яаралтай тусламжийн үйлчилгээнд ноцтой зөрчил гаргаж хариуцлага алдсан тохиолдолд захилгын шийтгэл оногдуулна. / хөдөлмөрийн тухай хууль, захиргааны хэргийн тухай хууль, ЭМС-ын бусад холбогдох хууль эрхийн дагуу захирлын тушаал /

11.1.2 Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн ёс зүйн харилцааны доголдол гаргасан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

11.1.3 Тасгийн дотоод бүтэц зохион байгуулалт зохицуулах болон ажилчдын ажиллах хуваарийг гаргаж, үүрэг даалгавар өгч ажиллах

11.1.4 Тасгийн чанарын үйл ажиллагааг хянаж нийт ажилчдын алдаа дутагдал болон эрсдэлийн байдалд хяналт тавьж ажиллах

11.1.5 Эмнэлгийн захиргаа болон бусад дээд шатны байгууллагуудын шийдвэрийг хөрсөнд буулгаж тасгийн үйл ажиллагаанд тусгаж ажиллах

11.1.6 Дотоод хяналт хийж дүгнэлт гаргах

11.1.7 Ажлыг улирал, жилээр дүгнэж тасгийн үйл ажиллагааг тогтвортой сайжруулах

11.1.8 Ажилчдын тасралтгүй суралцах үйл ажиллагааг дэмжиж дотоод болон гадаад сургалтад хамрагдах бололцоог хангаж мэргэжлийн хамт олон бүрдүүлж ажиллах

11.2 ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН АХЛАХ СУВИЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА

11.2.1 Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт заасан үүрэг биелүүлээгүй байгууллагын дотоод журам зөрчсөн яаралтай тусламжийн үйлчилгээнд ноцтой зөрчил гаргаж хариуцлага алдсан тохиолдолд захилгын шийтгэл оногдуулна. / хөдөлмөрийн тухай хууль, захиргааны хэргийн тухай хууль, ЭМС-ын бусад холбогдох хууль эрхийн дагуу захирлын тушаал /

11.2.2 Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн ёс зүйн харилцааны доголдол гаргасан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

11.2.3 Сувилахуйн стандартыг нийт сувилагч нарт мөрдүүлж сургаж ажиллах

11.2.4 Шинэ ажилтан сургах, дадлагажуулах

11.2.5 Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангуулан ажиллах

11.2.6 Сувилахуйн дотоод хяналт, үр дүнг тооцох

11.3 ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН СУВИЛАГЧИЙН ХАРИУЦЛАГА

11.3.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан, /чөлөө, ээлжийн амралт дууссан /тохиолдолд хариуцлага хүлээнэ.

11.3.2 Яаралтай тусламжийн тасагт 24 цагийн тасралтгүй тусламж үйлчилгээг үзүүлнэ

11.3.3 Сувилахуйн гардан үйлдлийн стандартын баримталж ажиллах

11.3.4 Эрэмбэлэн ангилалтыг эмс-ын А/814 тушаалын дагуу хийж эмчийг дуудан эрэмбийн дагуу үзүүлэх

11.3.5 Захад болон төвд ойр том диаметртэй судсан уян зүү байрлуулах чадвар эзэмшсэн байх/ гар, хөл чамархай, гүрээний вен /хамаарна

11.3.6 Амилуулах суурь болон лавшруулсан тусламжийг багаар үзүүлэх чадвар эзэмшсэн байх

11.3.7 Маш хүнд, ухаангүй хүнд сувилгаа, асаргаа хийх

11.3.8 Эрт сэрэмжлүүлэх үнэлгээг хийж эмчид мэдээлэх

11.3.9 Улаан эрэмбийн эмчлүүлэгчийн хяналт эмчилгээг хийж, эрчимт эмчилгээний хуудас хөтөлсөн байх

11.4 ЖИЖҮҮР ЭМЧ НАР БОЛОН БУСАД ХАМТАРЧ АЖИЛЛАХ ЭМЧ НАРЫН ХАРИУЦЛАГА

- 11.4.1 Яаралтай тусламжийн тасагт 24 цагийн тасралтгүй тусламж үйлчилгээг үзүүлнэ
- 11.4.2 Эмчлүүлэгчийг эрэмбэлэн ялгалтын хүлээгдэж болох минутад багтаж ирж үзсэн байх
- 11.4.3 Ажиглалт эмчилгээний хэсэгт эмчлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд заалт болон шийдвэрийг тодорхой гаргасан байх
- 11.4.4 Ажиглалт эмчилгээний хэсэгт эмчилсэн хүнийг дараагийн жижүүр эмчид өөрийн биеэр танилцуулан хүлээлгэж өгөх
- 11.4.5 Яаралтай тусламжийн тасагт дуудагдаж ажиллах, утсаа авахгүй байх тохиолдолд байгууллагын дотоод журам, захирлын тушаалаар хариуцлага тооцно.
- 11.4.6 Жижүүрийн хугацаанд хүний биеийн байдлыг үнэлэхгүйгээр эмчилгээ оношлогоо төлөвлөхгүй байх
- 11.4.7 Яаралтай тусламжийн тасагт дуудагдсан бусад тасгийн эмч нар ирэх ёстой цагт ирж үзлэг хийнэ
- 11.4.8 Яаралтай тусламжийн эмчийн эмчилгээ шийдвэрийг дуудагдаж ирсэн шууд өөрчлөхийг хориглоно.Зөвхөн санал оруулна, өөрийн үзлэг,дүгнэлтэд хийгдэж байгаа эмчилгээг оруулахгүй
- 11.4.9 Дуудагдаж ирсэн эмч Ehealth -ийн эмчийн тэмдэглэл хэсэгт бүх тохиолдолд өөрийн үзлэг,эмчилгээ, оношилгоо, шийдвэрийг тэмдэглэж үлдээнэ.
- 11.4.10 Яаралтай тусламжийн эмчийн шийдвэрийг илтээр эсэргүүцэх, маргалдах, нэр төрд халдах тохиолдолд ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн гэж үзнэ.

АРАВ ХОЁР. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТ

- 12.1 Эрүүл мэндийн бүх ажилтнууд ЭТҮХХалдварыг баримтлахын зэрэгцээ эмнэлгийн бусад үйлчлүүлэгчдэд олон эмд дасалтай нянгийн халдвар тараахаас чанд сэргийлэх
- 12.2 Гар ариутгах нь халдвараас сэргийлэх үр дүнтэй арга бөгөөд эрүүл мэндийн бүх ажилтнууд дараах зааврыг баримтална
- 12.3 Санитол гар ариутгах гелийг бүх ажилтнууд хэрэглэнэ
- 12.4 Эмчлүүлэгчийн өрөөнд орохын өмнө болон орсны дараа (хаалга, хөшиг, орны орчим гэх мэт)
- 12.5 Бээлий өмсөхийн өмнө
- 12.6 Эмчлүүлэгчид хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- 12.7 Эмчлүүлэгчийн орчин хүрэхийн өмнө болон хүрсний дараа
- 12.8 Гараа савандаж угаах:
 - Цус, бусад биеийн шингэнд хүрэлцсэний дараа
 - Гар бохирдсон үед
 - Бээлий тайлсны дараа
- 12.9 Бээлий
 - Эмчлүүлэгчийн биеийн шингэн, боолт, шарханд хүрэх бүх тохиолдолд нэг удаагийн бээлий өмсөнө

- Эмчлүүлэгчийн өрөө хооронд бээлийг солино.
- 12.10 Нэг удаагийн халад
- Олон эмийн тэсвэртэй нянтай эмчлүүлэгчид том талбайгаар хүрэлцэх үед (эмчлүүлэгчийг эргүүлэх гэх мэт)
 - Халдвар, клон үүссэн үед
 - i. MRSA
 - ii. Ванкомицинд тэсвэртэй Энтерококк
 - iii. Олон эмэнд тэсвэртэй грам сөрөг нян
 1. Түлэгдэл
 2. Халууралт нейтропени
 3. Дархлаа дарангуйлагдсан эмчлүүлэгч (халдвар хамгааллын журамд зааснаар)
- 12.11 **Яаралтай тусламжийн тасаг дахь халдвар хамгааллын дэглэмийн багцууд:**
- 12.11.1 Уян зүүний иж бүрдэл
 - 12.11.2** Катетрын иж бүрдэл
 - 12.11.3 Хамрын чихээсний иж бүрдэл
 - 12.11.4 Халуун хүйтэн жин бигнүүр
 - 12.11.5 Бүтэн биеийн угаалгын иж бүрдэл
 - 12.11.6 Толгой угаах иж бүрдэл
 - 12.11.7 Нугасны хатгалтын иж бүрдэл
 - 12.11.8 Төвийн венийн хүрцтэй холбоотой багц
 - 12.11.9 Гэмтлийн үеийн тусламж үзүүлэх иж бүрдэл/ бүх төрлийн чиг, бүх төрлийн бэхэлгээ, чангалуур, ороох боох материал, оёдлын багц, цус тогтоох эм тариа, дамнуурга/
 - 12.11.10 Амьсгалын зам чөлөөлөх иж бүрдэл
 - 12.11.11 Бикс, багаж ариун материалыг 72 цаг хугацаа хэтэрсэн, хэрэглэсэн тохиолдол бүрд өгнө.
 - 12.11.12 Томоохон хэмжээний инвазив ажилбар хийгдэж байгаа бүх тохиолдолд асептик техникийг баримтална.
 - 12.11.13 Гарын халдваргүйтгэл: мэс заслын сойзоор хлоргексидиний уусмалаар 1 минутаас дээш
 - 12.11.14 Ариун хамгаалалт: халат, маск, малгай, бээлий, ариун хаалт
 - 12.11.15 70%-ийн спиртэнд 2%-ийн хлоргексидиний уусмаар арьсыг арчих
 - 12.11.16 Хурц үзүүртэй зүйлсийг хаях
 - 12.11.17 Ажилбарыг гүйцэтгэж буй хүн хурц үзүүртэй бүх зүйлийг аюулгүй хайрцагт хаях үүрэгтэй (зүү, хутганы ир зэрэг).
 - 12.11.18 Төв венийн гуурс тавьсны дараа бүртгэж, тандалтын хуудас хөтөлнө.
- АРВАН ХОЁР. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСГИЙН ЭМ ЭМНЭЛГИЙН НЭГ
УДААГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

ЭМС-ЫН 2009 ОНЫ 388 ТООТ ТУШААЛ, 2019 ОНЫ А/293 ТООТ ТУШААЛЫН ДАГУУ
 БОЭТ-ИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ЭМ,
 ТАРИА, НЭГ УДААГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт1

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Тоо хэмжээ
1.Бактерийн эсрэг/ антибиотикууд /				
1	Цефазолин	1гр	фл	24
2	Ампициллин	1гр	фл	24
3	Метронидазол	100мл	фл	12
4	Ципринол	200мг/100мл	фл	24
2.Эпилепсийн эсрэг хэрэглэх бэлдмэл				
5	Карбамазепин	200мг	шах	10
3.Ерөнхий мэдээгүйжүүлэг бэлдмэл				
6	Тиофентал натри	0.5г-1г	фл	2
4. Булчин сулруулах, холинэстразийн эсрэг бэлдмэл				
7	Прозерин/ неостигмин /	0.5мг/мл	ам	2
5. Хэсгийн мэдээгүйжүүлэх бэлдмэл				
8	Лидокайн	2%-2мл	ам	20
9	Новокайн	0,25%-100мл	фл	2
6.Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих				
10	Эпинефрин	0,1%-1мл	ам	80
11	Амиодарон	150мг/3мл	ам	5
12	Атропин сульфат	0,1%-1мл	ам	6
13	Панангин	10мл	ам	5
14	Карведилол	6.25мг,	шах	10
15	Дигоксин	250мг	шах	5
16	Лансорбид	5мг, 10мг	шах	20
17	Валидол	60мг	шах	5
18	Атенолол	50мг	шах	10
19	Бисопролол	5мг, 10мг	шах	10
20	Нитроглицерин	0,5мг	фл	1
7.Цусны даралт бууруулах				
21	Эналаприл	1,25мг/1мл	ам	5
22	Никардипин	1мг/мл	ам	5
23	Эналаприл	5мг/10мг	шах	10
24	Амлодипин	5мг/10мг	шах	10
25	Нифедипин	10мг/20мг	шах	10
26	Экватор	5/10мг 10/20мг	шах	10
27	Лозартан+гипотиазид	100/25	шах	10
28	Валсартан	160мг	шах	10
8.Гуурсан хоолойн агчлын үед хэрэглэх				
29	Аминофиллин	2,4мг/ам-10мл	ам	5
30	Магнийн сульфат	25%-10мл	ам	6

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам

31	Сальбутамол		фл	2
9.Харшлын ба анафилаксийн эсрэг				
32	Преднизолон	30мг-1мл	ам	3
33	Дексаметазон	4мг/1мл	ам	10
34	Кетотифен	1мг	Шах	10
10.Адреномиметик бэлдмэл				
35	Допамин	0,5%-5мл	ам	5
11.Өвдөлт намдаах, халуун бууруулах				
36	Метамизол натри	50%-2мл	ам	20
37	Ревалгин	5мл	ам	5
38	Дифенгидрамин /димедрол/	1%-1мл	ам	20
39	Диклофенак натри	50мг-3мл	ам	10
40	Кетопрофен	100мг/2мл	ам	20
41	Кетопрофен	100мг	шах	10
42	Ибуфпрофен	400мг	шах	10
43	Диклофенак натри	100мг	шах	10
44	Диклофенак натри	100мг	лаа	5
45	Кетопрофен	100мг	лаа	5
46	Ацетаминофен 125	125мг	лаа	10
47	Ацетаминофен 250	250	лаа	10
12.Цусны бүлэгнэлтэд нөлөөлөх				
48	Аминокапроны хүчил	5%-100мл	фл	5
49	Транексамын хүчил	50мг/5мл	ам	5
50	Дицинон	125мг/2мл	ам	5
51	Фитоменадион	0,1%-1мл	ам	5
13.Цусны бүлэгнэлтийн эсрэг				
52	Гепарин	5000ед-1мл	фл	5
53	Ацетилсалицилийн хүчил	100мг	фл	1
14.Калийн бэлдмэл				
54	Кальцийн хлорид	10%-10мл	ам	5
15.Бөөр шээсний замд нөлөөлөх/ шээлгэх эм, тариа/				
55	Фуросемид	1%-2мл	ам	20
56	Фуросемид	40мг	шах	10
57	Спиринолактон	25мг	шах	10
58	Гидрохлортиазид	25мг	шах	10
16.Шингэнүүд				
59	Натрийн хлорид	0.9%-100мл	фл	10
60	Натрийн хлорид	0.9%-500мл	фл	30
	Натрийн хлорид	0,9%-500 мл	фл	15
61	Рингерийн уусмал	250мл	фл	10
62	Рингерийн уусмал	500мл	фл	30
63	Глюкоз	5%-500мл	фл	5
64	Глюкоз	40%-40мл	ам	10
65	Глюкоз	5%-250мл	фл	3

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам

66	Глюкоз	5%-100мл	фл	3
67	Калийн хлорид	7,5%-100мл	фл	2
68	Декстран	70%-400мл	фл	2
69	Маннитол	100мл	фл	5
70	Маннитол	10%-250мл	фл	5
17.Бөөлжилтийн эсрэг				
71	Метоклопрамид	0,5%-2мл	ам	10
72	Метоклопрамид	10мг	шах	5
18.Агчил тавиулах				
73	Дротаверин	2%-2мл	ам	10
74	Дротаверин	40мг	шах	5
19.Витаминууд				
74	Аскорбины хүчил	5%-2мл	ам	60
75	Тиамин бромид	1мл	ам	30
20.Нүдний бэлдмэл				
76	Прокайн		фл	1
21.Антидотууд ба хордлого тайлах				
77	Идэвхжүүлсэн нүүрс		шах	20
78	Налоксан	0.4%-1мл	ам	2
79	Кальцийн глюконат	10%-10мл	ам	5
80	Уулгаж сэлбэх олон найрлагат давсны бэлдмэл/Хоросол /	27,9гр	шах	10
22.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тариа				
81	Морфин гидрохлорид	10мг/мл-1мл	ам	5
82	Диазепам	10мг-2мл	ам	10
83	Трамадол	50мг/1мл	ам	5
84	Диазепам	5мг	шах	10
85	Трамадол	100мг	лаа	5
86	Галоперидол	5мг	шах	10
87	Фентанил	0.0005%-2мл	ам	5
88	Дроперидол	5мг/мл-2мл	ам	2
	Кетамин	500мг/10мл	фл	1
23				
.Нэг удаагийн хэрэгсэл				
89	Эмнэлгийн вазелин	20гр	тюб	1
90	Уян бинт /өргөн, нарийн/		ш	12
91	Бинт		ш	5
92	Чангалуур		ш	2
93	Катетр		ш	10
94	Шээсний уут		ш	10
95	Дуслын систем		ш	25
96	Нугасны хатгалтын зүү /22G, 20G/	Нэг удаагийн	ш	5
97	Тариур	1гр	ш	5
98	Тариур	3гр	ш	10

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам

99	Тариур	5гр	ш	10
100	Тариур	10гр	ш	10
101	Тариур	20гр	ш	10
102	Уян зүү	18G	ш	10
103	Уян зүү	20G	ш	10
104	Уян зүү	22G	ш	10
105	Уян зүү	24G	ш	10
106	Хоосон вакумтеннер /зүүтэй/	Нэг удаагийн	ш	100
107	Мэс заслын утас /хайлдаг, хайлдаггүй/	Нэг удаагийн	ш	24
108	Мэс заслын хутганы ир /8,10,12/	Нэг удаагийн	ш	30
109	Мэс заслын бээлий	Нэг удаагийн	ш	30
110	Гипс/ өргөн, нарийн/	Нэг удаагийн	ш	12
111	Чагнуур		ш	2
112	Даралтны аппарат		ш	1
113	Пульсоксиметр		ш	1

**АМИЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖИД НЭН ШААРДЛАГАТАЙ ЭМ, ТАРИАНЫ
ХЭРЭГСЛИЙН ЖИШИГ ЖАГСААЛТ**

Хүснэгт2

	Яаралтай тусламжийн эм эмнэлгийн хэрэгсэл	Төрөл, тоо тус бүрийн 2-оос дээш хэмжээний нөөц бүрдүүлсэн байна	
1	Амьсгалын зам чөлөөлөх хэрэгсэл	Амьсгалын зам чөлөөлөх хэрэгсэл /ам, хамраар агаар оруулагч/	Нялхас, хүүхдийн, насанд хүрэгчдийн
		Соруулах хэрэгсэл	Хүүхдийн болон насанд хүрэгчдийн
		Соруулын гуурс	Жижиг, том
2	Амьсгал дэмжих	Амбуны хошуувч	Нялхас, хүүхдийн, насанд хүрэгчдийн
		Амбу	Хүүхэд, насанд хүрэгчдийн
3	Цусны эргэлт дэмжих	Тарилгын иж бүрдэл	Тариур /3-20/мл
		Спирттэй хөвөн	Шаардлагатай хэмжээгээр
		Чангалуур	Хүүхэд насанд хүрэгчдийн
		Судасны гуурс	18G 20G 22G 24G
		Эпинефрин	1 мг/1мл-5 туншил
		Натри хлоридын уусмал	0,9%-500мл-10 уут
		Глюкозын уусмал	10%
4	Дефибриллятор	AED /автомат тохируулгат дефибриллятор/	Мэргэжлийн болон энгийн байж болно
5	Бусад	Ариутгалын уусмал	
		Амилуулах тусламжийн дарааллыг харуулсан хуудас, зөвлөмж заавар	Шаардлагатай газруудад байрлуулах
		Хүчилтөрөгч бортого	/5-10мл багтаамжтай/ урсгал тохируулагч ийн хамт
		Хүчилтөрөгчийн хошуувч, хамрын хос гуурс	Тус бүр 2-оос хүрэлцээтэй нөөцтэй

Яаралтай тусламжийн үйл ажиллагааг зохицуулах журам

		Даралтны аппарат	Хүрэлцээтэй нөөцтэй
		Биеийн дулаан хэмжигч	Хүрэлцээтэй нөөцтэй
		Чагнуур	Хүрэлцээтэй нөөцтэй
		Пульсоксиметр	Хүрэлцээтэй нөөцтэй
		Цусны глюкоз хэмжигч	Хүрэлцээтэй нөөцтэй

Яаралтай туёламжийн ТАСГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт3

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Байх ёстой тоо ширхэг	Одоо байгаа тоо
1.	Ор	8	4
2.	Амьсгалын аппарат /зөөврийн/	1	1
3	Утлагын аппарат	1	-
4	Монитор	9	1
5	Дуслын памп	10	-
6	Шахуургын памп	5	-
7	Ханын нэгдсэн систем / хүчилтөрөгч, соруулга/	8	5
8	Штатив	10	3
9	Даралтны аппарат	8	1
10	Чагнуур	8	2
11	Яаралтай тэргэнцэр	5	1
12	Сувилагчийн тэргэнцэр	3	1
14	Дефибрилятор	2	1
13	Эхо	1	-
14	Зүрхний бичлэг хийх аппарат	1	1
15	Артерийн цусны хийн шинжилгээ	1	-
16	Сахрын аппарат	3	1
17	Хүчилтөрөгчийн баллон	2	-
18	Соруулгын аппарат	1	-
19	Капнограф	1	-
20	Автомат дефибрилятор	2	-

17.4 ЯТТ-ийн анхан шатны бичиг баримтын жагсаалт

17.4.1 Яаралтай тусламжийн үйлчлүүлэгчдийн журнал / насанд хүрэгчид/

17.4.2 Уян зүүний тандалтын хуудас

17.4.3 Катетарийн тандалт

17.4.4 Яаралтай эм тарианы орлого, зарлага

17.4.5 Зөвшөөрлийн хуудас

17.4.6 Эмчилгээ үйлчилгээнээс татгалзах хуудас

17.4.7 Амилуулах тусламжийн маягт

17.4.8 Хорт мансууруулах эм тарианы орлого, зарлага

17.4.9 Хөдөлгөөны журнал

17.4.10 Техник ашиглалтын журнал

17.4.11 Дуудлагын журнал

17.4.12 Түргэн тусламжийн хуудас / хүүхэд/

17.4.13 Алсын дуудлагын хуудас

17.4.14 Алсын дуудлагын журнал

17.4.15 Илүү цагийн бүртгэл

17.4.16 Хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэл

